

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХӨХҮҮЛЭН ДЭМЖИХ, ХАРИЛ-
ЦАН ХАМГААЛАХ, ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЗАС-
ГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан
Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэж
нэрлэнэ/

хоёр улсын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг бэх-
жүүлэн өргөтгөхийг хүсч,

нэг улсын хөрөнгө оруулагчаас нөгөө улсын нутаг дэвсгэрт
хөрөнгө оруулах таатай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэн,

энэхүү Хэлэлцээрийн дагуу хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэм-
жих, харилцан хамгаалах нь хоёр улсын эдийн засгийн хөгжилд
тус дөхөм үзүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрч,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Нэр томъёо

Энэхүү Хэлэлцээрт:

I. "Хөрөнгө оруулалт" гэж мөнгөөр үнэлж болох бүх төрлийн
эд хөрөнгө, тухайлбал дор дурдсан эд хөрөнгийг хэлэх боловч
зөвхөн эдгээрээр үл хязгаарлагдана. Үүнд:

-хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө болон өмчийн аливаа эрх,
түүний дотор барьцаа, эд хөрөнгө саатуулан барих эрх, банк,
санхүүгийн бусад байгууллагын данс дахь хөрөнгө,

-Хэлэлцэн тохирогч Тал тус бүрийн хууль тогтоомжийн дагуу
бүртгэгдсэн болон хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэр, хувь нийлүүл-
сэн нийгэмлэг, аж ахуйн болон нөхөрлөлийн байгууллагууд, хуулийн

2.

бусад этгээдийн хувьцаа, ногдол хувь, облигац, болон тэдгээрт оролцох бусад аливаа хэлбэр,

-хөрөнгө оруулалттай холбогдсон зээл, тусгай зориулалт бүхий банкны болон санхүүгийн хадгаламж, бусад мөнгөн нэхэмжлэл,

-оюуны болон үйлдвэрийн өмчийн эрх түүний дотор зохиогчийн эрх, патент, барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, пүүсийн нэр, үйлдвэрийн загвар, худалдааны нууц болон ноу-хау,

-дахин хөрөнгө оруулалтаас орсон орлого, үндсэн ер болон зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх хүү.

2. "Хөрөнгө оруулагч" гэж:

а/Хэлэлцэн тохирогч аль нэг Талын улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийнх нь дагуу түүний харьяат болох хувь хүн;

б/Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийнх нь дагуу байгуулагдсан аливаа хуулийн этгээд;

в/Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаагүй боловч тухайн Хэлэлцэн тохирогч Талын хувь хүн эсхүл хуулийн этгээдийн шууд буюу шууд бус хяналтад байдаг хуулийн этгээдийг тус тус хэлнэ.

3. "Орлого" гэж хөрөнгө оруулалт, түүнтэй холбогдсон үйл ажиллагааны үр дүнд олсон орлого, бэлэн мөнгө буюу биет зүйл, түүний дотор ашиг, ногдол ашиг, үйлдвэрлэлийн урамшил, техникийн үйлчилгээний болон бусад хууль ёсны аливаа орлогыг хэлнэ.

4. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын улсын хууль, хууль тогтоомжийн бусад актын дагуу тухайн улсын нутаг дэвсгэрт оруулсан эд хөрөнгийн хэлбэрийг өөрчлөх нь хөрөнгө оруулалтын мөн чанарыг үл хөндөнө.

3.

Хоёрдугаар зүйл

Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн
дэмжих, хамгаалах

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулахад тус дөхөм үзүүлж, тийнхүү хөрөнгө оруулахыг өөрийн хууль тогтоомжийн дагуу зөвшөөрнө.

2. Хэлэлцэн тохирогч Тал тус бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас оруулсан хөрөнгө оруулалтад шударга, эрх тэгшээр хандах бөгөөд зоргоороо буюу ялгаварлан гадуурхах арга хэмжээ авах замаар хөрөнгө оруулалтаа эрхлэн хөтлөх, ашиглах буюу захиран зарцуулах эрхийг хаан боогдуулж болохгүй.

Гуравдугаар зүйл

Хөрөнгө оруулалтын эрх зүйн
нөхцөл

1. Хэлэлцэн тохирогч Тал тус бүр нь өөрийн нутаг дэвсгэрт оруулсан хөрөнгө оруулалтад өөрийн дотоодын хөрөнгө оруулагчид болон гуравдагч орны хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад олгодгоос дутуутгүй таатай нөхцөл олгоно.

2. Энэхүү нөхцөл нь дараах тохиолдолд хамаарахгүй:

а/Хэлэлцэн тохирогч аль нэг Тал гааль, эдийн засгийн болон чөлөөт худалдааны холбоонд хамтран оролцож байгаагийн улмаас зарим улс орны хөрөнгө оруулагчдад давуу эрх олгодог бол:

б/Хэлэлцэн тохирогч аль нэг Тал давхар татвар ногдуулахаас зайлсхийх тухай хэлэлцээр болон татварын асуудлаарх бусад хэлэлцээрийн заалтын дагуу зарим улс орны хөрөнгө оруулагчдад давуу эрх олгодог бол.

4.

Дөрөвдүгээр зүйл

Хөрөнгийг албадан хураах

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчаас оруулсан хөрөнгө оруулалтыг нийтийн ашиг сонирхлыг хөндөхөөс бусад тохиолдолд улсын өмч болгох, дайчлан гаргуулах, албадан хураах эсхүл улсын өмч болгох, дайчлан гаргуулах, албадан хурааж авахтай адил үр дагавар бүхий арга хэмжээ /цаашид "Албадан хураах" гэх/ авахыг хориглоно.

Албадан хураалт нь:

- хууль тогтоомжид заасан журмын дагуу явагдана.
- ялгаварлан гадуурхахгүй байх үндсэн дээр явагдана.
- хохирлыг бүрэн хэмжээгээр, зүй бусын сааталгүйгээр нөхөн төлөх ёстой.

Албадан хураасан эд хөрөнгийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ нь түүнийг албадан хураахаас өмнөхөн буюу албадан хураах талаар нийтэд мэдэгдэхийн өмнөх үеийн /чухам аль нь эхэлж тохиолдсоноос шалтгаална/ зах зээлийн үнэлгээтэй дүйцсэн байвал зохино.

Нөхөн төлбөрт энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлийн хоёрдахь хэсэгт заасан үйл явдал тохиолдсон цаг хугацаа болон нөхөн төлбөрийг төлөх хугацааны хооронд ногдох хүүгийн төлбөрийг оролцуулж тооцсон байна. Нөхөн төлбөрийг хөрөнгө оруулалт хийсэн валютаар, эсхүл хөрөнгө оруулагчийн зөвшөөрснөөр бусад аль ч валютаар хийж болно. Нөхөн төлбөрийг хязгаарлалгүй, зүй бусын сааталгүйгээр гадаадад шилжүүлнэ.

Тавдугаар зүйл

Хохирлыг нөхөн төлөх

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэрт дайн, зэвсэгт бусад мөргөлдөөн, онц байдал, эсхүл тэдгээртэй

адилтгах бусад нөхцөл байдлын улмаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтад хохирол учирсан байвал хохирлыг нөхөн төлөх асуудлын хувьд Хэлэлцэн тохирогч тухайн Тал нь өөрийн эсхүл гуравдагч орны хөрөнгө оруулагчдад олгогдгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

Ийм төлбөрийг гадаадад чөлөөтэй шилжүүлнэ.

Зургадугаар зүйл

Хөрөнгө оруулалттай холбогдсон
төлбөрийг шилжүүлэх

I.Хэлэлцэн тохирогч Талууд хөрөнгө оруулалттай холбогдсон төлбөрийг өөрсдийн хууль тогтоомжид заасан журмын дагуу зүй бусын сааталгүйгээр, чөлөөтэй шилжүүлэх баталгаа өгнө.Талуудын хууль тогтоомжид дараах зүйл тусгагдсан байж болно.Үүнд:

-төлбөрийг чөлөөтэй шилжүүлэх эрхийг баталгаажуулсан шилжүүлгийн бичиг баримтыг бүрдүүлэх журам,

-татвар, хураамж болон шилжүүлэг хийх үйлчилгээнээс авах хураамж,

-зээлдүүлэгчдийн хууль ёсны эрхийг хамгаалах буюу шүүн таслах ажиллагааны явцад гаргасан шийдвэрийг биелүүлэх явдлыг хангах,

-энэхүү зүйлд заасан журам нь шударга, ялгаварлалгүй байх ёстой.

Энэхүү Хэлэлцээрт заасан шилжүүлэгт:

-анхны хөрөнгө оруулалтын эд хөрөнгө, мөн түүнчлэн хөрөнгө оруулалтын хэвийн ажиллагааг хангах буюу өргөжүүлэхэд шаардагдах гадаадын нэмэлт хөрөнгө,

-энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлийн дагуу хийх нөхөн төлбөр,

6.

-хөрөнгө оруулалтын талаарх маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон төлбөр,

-зээлийн хэлэлцээрийн дагуу хийгдэх төлбөр, мөн оюуны болон үйлдвэрийн өмчийн эрхтэй холбогдсон урамшуулал, гэрээгээр тохиролцсон удирдлага, техникийн болон үйлчилгээний хөлс,

-энэхүү Хэлэлцээрийн тавдугаар зүйлийн дагуу хохирлыг нөхөн төлөх төлбөр,

-хөрөнгө оруулалттай холбоо бүхий ажил гүйцэтгэж буй Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хувь хүнд тогтмол төлж байгаа хөдөлмөрийн хөлсний зохих хувь,

-хөрөнгө оруулалтыг борлуулсан эсхүл бүхэлд нь буюу хэсэгчлэн татан буулгаснаас олсон орлого тус тус багтана.

2.Шилжүүлэг нь зүй бусын сааталгүйгээр, чөлөөтэй хөрвөх валютаар, шилжүүлэг хийх тухайн өдөр мөрдөж буй ханшаар хийгдэнэ.

Шилжүүлэг хийхтэй холбогдсон зохих журмыг гүйцэтгэхэд шаардлагатай цаг хугацаанд нь хийгдсэн шилжүүлгийг "зүй бусын сааталгүй" гэж тооцно.

Долдугаар зүйл

Бусад журмыг хэрэглэх

Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль эсхүл олон улсын эрх зүйгээр хүлээсэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үүрэг, Хэлэлцэн тохирогч Талууд тохиролцож энэхүү Хэлэлцээрт оруулсан нэмэлт еөрчлөлтийн ерөнхий буюу тусгай заалтаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтад олгох нөхцөл нь энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөлөөс илүү таатай байвал аль илүү таатайг нь эдлүүлнэ.

Наймдугаар зүйл

Эрхийг шилжүүлэх

1. Хэлэлцэн тохирогч нэг Тал эсхүл түүний томилсон аливаа байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оруулсан хөрөнгө оруулалтын талаар гаргасан баталгаа болон даатгалын хэлцлийн дагуу өөрийн улсын аливаа хөрөнгө оруулагчдад төлбөр хийх нөхцөлд Хэлэлцэн тохирогч хоёрдахь Тал тухайн хөрөнгө оруулагчийн аливаа эрх, гомдлын шаардлага, нэхэмжлэлийг Хэлэлцэн тохирогч анхны Тал эсхүл түүний томилсон байгууллагад шилжсэнийг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө оруулагчийн эрхийг ийнхүү авсан Хэлэлцэн тохирогч Тал эсхүл түүний томилсон аливаа байгууллага хөрөнгө оруулалттай холбогдсон даатгалын талаарх үүргийн хувьд тайлбар хийх, эрхээ шилжүүлсэн хөрөнгө оруулагчийн эдэлж байсан эрхийг хэрэгжүүлэх, гомдлын шаардлага, нэхэмжлэлийг хангуулах эрх эдэлнэ.

2. Энэхүү зүйлийн 1-д заасны дагуу эрх шилжсэн тохиолдолд эрхээ шилжүүлсэн хөрөнгө оруулагч эрхийг шилжүүлэн авсан Хэлэлцэн тохирогч Тал эсхүл түүний томилсон аливаа байгууллагын зөвшөөрөлгүйгээр гомдлын шаардлага тавих ёсгүй.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын хоорондын маргааныг шийдвэрлэх

1. Энэхүү Хэлэлцээрийн заалтыг тайлбарлах, хэрэглэх талаар Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд үүссэн маргааныг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

2. Хэрэв Хэлэлцэн тохирогч Талууд маргаан үүссэн өдрөөс хойш 6 сарын дотор маргааныг шийдвэрлэх талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр маргааныг гурван гишүүний бүрэлдэхүүнтэй Арбитрийн шүүхэд шилжүүлнэ. Хэлэлцэн тохирогч Тал тус бүр нэг арбитрчийг томилох

8.

бөгөөд ийнхүү хоёр талаас томилогдсон арбитрчид шүүхийн даргаар гуравдагч арбитрчийг сонгоно. Тэрээр Хэлэлцэн тохирогч Талуудтай дипломат харилцаа бүхий гуравдагч улсын иргэн байх ёстой.

3. Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь арбитрч томилогүй буюу ийм томилолтыг хоёр сарын дотор хийх тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талын саналыг хэрэгсэхгүй бол Хэлэлцэн тохирогч сүүлчийн Талын хүсэлтээр арбитрчийг Гаага хотноо төвтэй Олон улсын шүүхийн Ерөнхийлөгч томилж болно.

4. Хэрэв хоёр арбитрч томилогдсноосоо хойш хоёр сарын дотор шүүхийн даргыг сонгох талаар тохиролцоонд хүрч чадахгүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр шүүхийн даргыг Олон улсын шүүхийн Ерөнхийлөгч томилж болно.

5. Олон улсын шүүхийн Ерөнхийлөгч энэхүү зүйлийн 3,4-т заасан үүргийг гүйцэтгэх бололцоогүй буюу тэрээр Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн бол Олон улсын шүүхийн дэд ерөнхийлөгч арбитрчдыг томилно. Хэрэв Олон улсын шүүхийн дэд ерөнхийлөгч тухайн үүргийг гүйцэтгэх боломжгүй буюу тэрээр Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн бол, Хэлэлцэн тохирогч аль аль Талын иргэн бус, Олон улсын шүүхийн дэд ерөнхийлөгчийн удаах тушаалтан арбитрчдыг томилж болно.

6. Арбитрын шүүх нь Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд тохиролцсон бусад тохиролцоог зөрчихгүйгээр шүүн таслах ажиллагааны дэгээ өөрөө тогтоож болно. Шүүх шийдвэрээ олонхийн саналаар гаргана.

7. Хэлэлцэн тохирогч Тал тус бүр шүүхийн бүрэлдэхүүн дэх өөрийн гишүүний болон шүүн таслах ажиллагаанд өөрийгөө төлөөлүүлсний зардлыг тус тус хариуцна. Шүүхийн даргын болон бусад зардлыг Хэлэлцэн тохирогч Талууд тэнцүү хэмжээгээр хариуцна. Гэвч шүүх нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль нэгэнд зардлын ихэнх хэсгийг ногдуулахаар өөрийн шийдвэрт зааж болох бөгөөд ийм шийдвэрийг Хэлэлцэн тохирогч хоёр Тал заавал биелүүлнэ.

9.

8.Шүүхийн шийдвэр нь эцсийн байх бөгөөд Хэлэлцэн тохирогч Талууд түүнийг заавал биелүүлэх үүрэгтэй.

Аравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хоорондын маргааныг шийдвэрлэх

1.Энэхүү Хэлэлцээрийн есдүгээр зүйлийн заалтыг хөндөхгүйгээр Хэлэлцэн тохирогч аль нэг Тал болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хооронд хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх үүднээс сонирхогч талуудын хооронд хэлэлцээ явуулна.

2.Хэлэлцээ явуулж эхлэх тухай бичгээр гаргасан саналыг хүлээн авснаас хойш 6 сарын дотор хэлэлцээ хийж, шийдвэр гаргаж чадаагүй бол маргаанд оролцогч Талууд маргааныг:

а/Энэхүү Хэлэлцээрийн 4,5,6 дугаар зүйлд заасан үүргийн талаарх маргааныг шийдвэрлүүлэхээр хөрөнгө оруулагчийн хүсэлтээр Арбитрын шүүхэд;

б/Энэ зүйлийн 2-ын "а"-д заагаагүй маргааныг маргаанд оролцогч хоёр Талын зөвшөөрснөөр Арбитрын шүүхэд тус тус шилжүүлнэ.

3.Арбитрын шүүхийг маргаан үүсэх бүрт байгуулна.Хэрэв маргаанд оролцогч талууд өөрөөр тохиролцоогүй бол тал тус бүр нэг арбитрчийг томилно.Томилогдсон хоёр арбитрч гуравдагч улсын иргэнийг шүүхийн даргаар сонгоно.Маргааныг Арбитрын шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өдрөөс хойш хоёр сарын дотор арбитрчидыг, дараагийн хоёр сарын дотор шүүхийн даргыг тус тус томилсон байна.

4.Энэ зүйлийн 3-т заасан хугацаанд арбитрчид, шүүхийн даргыг томилж чадаагүй тохиолдолд өөр тохиролцоо байхгүй бол маргаанд оролцогч аль нэг тал Парис хот дахь Олон улсын худалдааны Танхимын дэргэдэх Арбитрын шүүхийн даргад хандаж, арбитрчид, шүүхийн даргыг томилуулах хүсэлт тавьж болно. Арбитрын шүүхийн дарга нь энэ үүргийг гүйцэтгэх боломжгүй буюу тэрээр Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн бол энэхүү Хэлэлцээрийн есдүгээр зүйлийн 5-д заасантай адил журмыг баримтална.

5.Талууд өөрөөр тохиролцоогүй бол Арбитрын шүүх шүүн таслах ажиллагааны дэгээ өөрөө тогтооно. Шүүхийн шийдвэр нь эцсийн байх бөгөөд заавал биелэгдэх ёстой. Хэлэлцэн тохирогч Тал тус бүр Арбитрын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх үүрэгтэй.

6.Маргаанд оролцогч тал тус бүр нь шүүхийн бүрэлдэхүүн дэх өөрийн гишүүний болон шүүн таслах ажиллагаанд өөрийгөө төлөөлүүлсний зардлыг тус тус хариуцна. Шүүхийн даргын болон бусад маргаанд оролцогч талууд тэнцүү хэмжээгээр хариуцна. Гэвч шүүх нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль нэгэнд зардлын ихэнх хэсгийг ногдуулахаар өөрийн шийдвэрт зааж болох бөгөөд энэ шийдвэрийг хоёр тал заавал биелүүлэх үүрэгтэй.

7.Хөрөнгө оруулагч өөрт учирсан хохирлыг даатгалын гэрээний дагуу бүхэлд нь буюу хэсгийг нь нөхөн төлбөрөөр төлүүлснийг маргаанд оролцогч Хэлэлцэн тохирогч Тал шүүн таслах ажиллагааны болон шүүхийн шийдвэрийг биелүүлэх аль ч үе шатанд өөрийгөө хамгаалах үндэс болгох ёсгүй.

8.Хэлэлцэн тохирогч хоёр Тал "Улс орон болон нөгөө улс орны иргэний хооронд хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай" 1965 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн Вашингтоны Конвенцид нэгдэн орсон тохиолдолд аливаа маргааныг Хөрөнгө оруулалтын талаарх маргааныг шийдвэрлэх олон улсын Төвд дараах журмаар шилжүүлнэ:

II.

-энэ зүйлийн 2-ын "а"-д заасан маргааныг хөрөнгө оруулагчийн шаардлагаар,

-энэ зүйлийн 2-ын "б"-д заасан маргааныг Хэлэлцэн тохирогч Талуудын зөвшөөрснөөр,

Арван нэгдүгээр зүйл

Төгсгөлийн заалтууд

1. Хэлэлцэн тохирогч Талууд өөр өөрийн хууль тогтоомжийн дагуу олон улсын хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох талаар хууль зүйн шаардлагыг биелүүлсэн тухай харилцан нот солилцоно.

Сүүлийн нотыг хүлээн авсан өдрөөс энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээрийг 10 жил/арван жил/-ийн хугацаатайгаар байгуулсан бөгөөд хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэ зүйлийн 6-гийн дагуу түүнийг дуусгавар болгох тухай хүсэлтээ гаргахгүй бол эл Хэлэлцээр тав таван жилээр аяндаа сунгагдана.

3. Энэхүү Хэлэлцээрийн заалтууд 1991 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс хойшх хөрөнгө оруулалтад хамаарна.

4. Энэхүү Хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө оруулсан хөрөнгө оруулалтын хувьд уг Хэлэлцээрийн заалтууд Хэлэлцээр хүчингүй болсон тэр өдрөөс хойшх 10 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

5. Талууд бичгээр тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Аливаа ийм нэмэлт өөрчлөлт нь тал тус бүр түүнийг хүчин төгөлдөр болгох талаар өөрийн хууль эрхийн бүхий л шаардлагыг биелүүлсэн тухайгаа бие биедээ харилцан мэдэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

12.

6. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Хэлэлцээрийг дуусгавар болгох тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа Хэлэлцээр хүчингүй болохоос нэг жилийн өмнө бичгээр мэдэгдэх замаар эхний 10 жилийн хугацаанд буюу түүнээс хойшх аль ч үед Хэлэлцээрийг дуусгавар болгож болно.

Дээр дурдсаныг нотлон зохих ёсоор эрх олгогдсон доорх эрх бүхий хүмүүс энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хэлэлцээрийг Алматы хотноо 1994 оны 12 дугаар сарын "2"-ны өдөр монгол, казах, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Энэхүү Хэлэлцээрийн заалтыг тайлбарлахад зөрүү гарвал орос хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

Аканур

ЦАХИМ ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ